



**БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант, 5-р баг, Булган сум, Булган аймаг,
63082, Утас/Факс: 7034-2580

Цахим шуудан: bulgan@audit.gov.mn

2025.04.21 № 423

танай _____ ны № _____ т

БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА
Д.ПҮРЭВ-ОЧИР ТАНАА

Сөрөг дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-д заасны дагуу аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь санхүүгийн тайланд материаллагаар нөлөөлсөн бөгөөд өргөн тархсаныг хангалттай, зохистой аудитын нотолгоонд үндэслэн нотолсны улмаас аймгийн ТЕЗ-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулаагүй гэж үзсэн.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аймгийн ТЕЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангаар ТЕЗ-ийн 1, ТТЗ-ийн 17, ТШЗ-ийн 44, орон нутгийн тусгай сангийн 35, ОНӨХХК болон ОНӨААТҮГ-ийн 13 нийт 110 байгууллага аудитад хамрагдсанаас 51 байгууллагад дүгнэлт гаргаж, 59 байгууллагыг түүвэрт хамруулсан.

“Хөдөө аж ахуй-Хөгжлийн ирээдүй” ОНӨХХК,” Сайхан сумын ЗДТГ, Сайхан сумын ТТЗ зэрэг 3 байгууллагын санхүүгийн тайланд “Татгалзсан дүгнэлт” өгчээ.

Сайхан сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн тайланд нэгтгэгдсэн 4 байгууллагаас сумын ЗДТГ-ын санхүүгийн тайланд “Татгалзсан” дүгнэлт өгч, 3 байгууллага нь үе шатны түүвэрт хамруулсан, “Хөдөө аж ахуй-Хөгжлийн ирээдүй” ОНӨХХК нь 2023 оны хөрөнгө оруулалтаар ирсэн Баяд үүлдрийн 51.6 сая төгрөгийн 250 тоо толгой хуц, 6.7 сая төгрөгийн 50 тоо толгойн эрчмийн хар ухна ишгийг түрээсийн гэрээгүйгээр нийт 58.4 сая төгрөгийн 300 тоо толгой богийг 1 иргэнд өгч 2024 онд 258 тоо толгой бог үхсэн гэх боловч малын эмчийн дүгнэлт

632502832

байхгүй, нотлох баримтгүй, өмнөх онд худалдан борлуулсан аймгийн нөөцийн өвс тэжээлээс 10,493 боодол өвс, 54 тн тэжээлийг худалдан борлуулснаас АЗД-ын 2024 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн А/74 тоот захирамжаар 1 боодол өвснөөс 500, 1 тн тэжээлээс 0.07 сая төгрөгийн орлогыг авах нөхцөлтэйгөөр худалдан борлуулсан үүнээс 10493 боодол өвсний 5.2, 54 тн тэжээлээс 3.8 сая төгрөг буюу нийт 9.0 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлээгүй, тайлант онд аймгийн нөөцийн өвс тэжээлээс 10,493 боодол өвс, 54 тн тэжээлийг худалдан борлуулсан 9.0, түрээсийн гэрээгээр 305 иргэн, 9 аж ахуйн нэгжид олгосон 1,482.8 сая төгрөгийн 1257 тоо толгойн бог, бод малыг гэрээний тусгай нөхцөлд заагдсан түрээсийн төлбөрийг авлагаар огт бүртгээгүй зэрэг зөрчлүүд илэрсэн нь санхүүгийн тайланг үнэн зөв илэрхийлснийг хангалттай бөгөөд зохистой нотолгоо олж авах боломжгүй, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10-д "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх.", 16 дугаар зүйлийн 16.5.2-д "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих;" 16.5.7-д "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах;" НББ-ийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4-д "Төсвийн байгууллага нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу санхүүгийн тайланг тайлагнаж, тушаана." 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.", 13.4-д "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна." 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.", 20 дугаар зүйлийн 2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;"; 20.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;"; Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4.1-д "эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд үнэн зөв, чанартай явуулж дуусгах;"; 73 дугаар зүйлийн 73.2-т "нэг эд хариуцагчийн хариуцлагад байсан нэг нэр төрлийн адил үнэтэй бараа материалын үнэт зүйлийн илүү дутууг хооронд нь харьцуулж хааж болно;" гэсэн заалтуудтай нийцээгүй, санхүүгийн тайлангийн аудитын "Эрх ба үүрэг", "Тохиолдсон байх", "Иж бүрэн байх", "Тасалбар болголт" гэсэн батламж мэдэгдлүүдийг хангаагүй тул аймгийн ТЕЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн дүгнэлтэд нөлөөлүүлэн санхүүгийн тайлан баталгаажуулах аудитаар илэрсэн нийт 1,933.2 сая төгрөгийн материаллаг зөрчлийн дүн нь гүйцэтгэлийн үе шатанд сонгосон материаллаг байдлын дүнгээс 1,004.8 сая төгрөгөөр давсан тул санхүүгийн тайлангийн үнэн зөв батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Аймгийн 2024 оны орон нутгийн төсвийн татварын орлогыг 55,142.1 сая төгрөгөөр, татварын бус орлогыг 30,425.3 сая төгрөгөөр тус тус орлого төлөвлөж, гүйцэтгэлээр татварын орлогыг 61,523.9 сая төгрөгөөр, татварын бус орлогыг

30,153.8 сая төгрөг буюу нийт 6,110.3 сая төгрөгөөр орлого илүү төвлөрүүлжээ.

Энэ нь сумд жилийн татварын орлогыг дутуу төлөвлөх, ирэх жилд шинээр нэмэгдэх аж ахуйн нэгж, газрын төлбөр, бууны татвар зэргийн орлогын төлөвлөлтийг дутуу гаргах, цалин хөлсний нэмэгдэл болон байгалийн нөөцөөс орж ирэх орлогуудын өөрчлөлтүүдээс шалтгаалсан гэж үзэж байна.

Аудитын гол асуудал

Азийн хөгжлийн банкны орон нутгийн хотуудын нийтийн аж ахуйг хөгжүүлэх МОН1907-2003 төслийн зээл 329.0, Азийн хөгжлийн банкны хот байгуулалтын салбарын МОН2301-2015 төслийн зээл 1,139.4, Азийн хөгжлийн банкны Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн МОН3713-2019 төслийн зээл 11,661.3, "Булган мээж" ОНӨХХК-ий 150.6 сая төгрөгийн тус тус зээлийн үлдэгдэлтэй байна.

2024 онд урт хугацаат зээлийн үндсэн төлбөрт 1,849.6, зээлийн хүүгийн төлбөрт 412.1 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс МОН1907-2003, МОН2301-2015 төслийн зээлийг хуваарийн дагуу төлж, МОН3713-2019 төслийн зээлийн хугацаа хэтэрсэн зээлийн төлбөрт 820.8 сая төгрөг тооцогджээ.

Бусад асуудлын хэсэг

Аймгийн ТЕЗ нь 2024 оны шилэн дансанд мэдээлсэн 154 мэдээллээс 6 мэдээг хугацаа хоцроож мэдээлсэн нь шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.1.2, 6.1.5 дахь заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН АЛБАН
ТУШААЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Ж.ЭНХЦООДОЛ